



Г.Нямдаваа, МУИС-ийн ШУС, БУС профессор
Ц.Сэр-Од, МУБИС-ийн МБУС-ийн Газарзүйн тэнхимийн багш, магистр
Ч.Билэгтмандах, ХИС-ийн БШТС-ийн Газарзүйн тэнхимийн багш

БАРУУН БҮС СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Abstract: The West region is one of the regions with comparatively feeble development of economics in Mongolia. There is an urgent need for our country to maintain and intensify the development of local regions and to develop multi-propped sectors of economics. We have tried to generalize the research conducted in the West region. The aim of the research was to study the problems facing with sectors of economics in the West Region.

Key words: region, regional development, territories and case studies

Бүс нутгийн хөгжил болон аливаа шинжлэх ухааны салбарын судалгаанд онол, аргазүйн үндэслэлийг авч үзэхэд тухайн объектын судлагдсан байдлын түүх буюу өмнөх үеийн судалгааны ажлын үр дүн, туршлагыг сайтар судлан мэдэж, түүнийг улам боловсронгуй болгох замаар хөгждөг нь судалгааны ажлын нэг чухал зарчим билээ. Иймд бид баруун бүсийн судалгааны асуудлаар өнөөгийн эрдэмтэн судлаачдын хэвлүүлсэн бүтээлийн жагсаалтад анализ хийж, зарим онцлогийг энэхүү илтгэлээр гаргахыг зорьсон юм.

Харьцангуй богино хугацаанд Баруун бүсийн нийгэм эдийн засаг, байгалийн нөхцөл нөөц, түүх соёл, эрхзүйн орчин зэрэг олон салбар чиглэлээр тусгайлан туурвисан ном, нэг сэдэвт зохиол, илтгэл, өгүүлэл зэрэг нийт 600 гаруй бүтээлийн жагсаалтад товч анализ хийж үзлээ.

Энэхүү ажлыг цаашид улам өргөжүүлэн, монгол орон төдийгүй гадаад дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлийг хамарсан эрдэм шинжилгээний ажлын мэдээллийн сан болгох бөгөөд эрхэм судлаачид та бүхэн ашиглах боломжтой, ялангуяа шинэ судалгааныхаа ажлыг эхэлж буй залуу судлаачдад чухал хэрэглэгдэхүүн болох юм.

Одоогоор баруун бүсийн судалгаатай ямар нэгэн байдлаар холбоотой 600 гаруй ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бүртгэгдсэнийг салбараар нь ангилж үзвэл:

250 гаруй нь буюу 42 хувь нь биологийн төрөл зүйл, тэдгээрийг хамгаалах, ашиглах чиглэлийн судалгааны материал, 110 гаруй буюу 18 хувь нь нийгэм, эдийн засгийн төрөл бүрийн асуудлыг хөндсөн судалгааны материал

байна. 160 гаруй буюу 27 хувь нь байгалийн шинжлэл, ашиглалт, хамгаалалтын чиглэлийн судалгааны материалууд хамрагдсан байна. Энэхүү чиглэлд химийн салбарынхны хийдэг нүүрс, усны чиглэлийн судалгааг хамт бүртгэсэн болно. Үлдсэн 80 орчим бүтээл буюу 13 хувь нь түүх соёл, угсаатны чиглэлийн судалгааны материалууд хамрагдсан байлаа.

Үүнээс харахад, баруун бүсийн судлаачид болон баруун бүсийг судалгааныхаа объект болгон сонгон авсан эрдэмтдийн судалгааны бүтээлийн дийлэнх хувийг биологийн төрөл зүйлийн судалгаа, удаах багтаамжийг байгалийн шинжлэл, газарзүйн судалгаа, гутгаар хэмжээг нийгэм эдийн засгийн судалгааны бүтээл, хамгийн бага хувийг түүх, соёл, угсаатны судалгааны материал эзэлж байна. Харин судлаачдын бүтцийг харахад биологийн чиглэлийн бүтээлийн тоо давамгайл боловч судлаачдын тоо төдий л олон бус нэг судлаачийн гаргаж буй бүтээлийн тоо харьцангуй их байгаа нь харагдаж байна. Иймд биологийн салбарын судлаачид аливаа төрөл зүйлийг судлахдаа нутаг дэвсгэрийн байршил, орон зайн онцлогийг түлхүү харгалзан үздэг, тухайн чиглэлээр дагнан ажилладаг гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Бүс нутгийн нөхцөл нь аливаа амьтны оршин буй бичил онцлог, бичил орчныг буй болгож, тэдгээрийг хамгаалах, зүй зохистой ашиглах өвөрмөц аргазүй шаарддаг. Харин бусад байгалийн шинжлэл, газарзүй, нийгэм, эдийн засаг, түүх соёл, угсаатны чиглэлийн эрдэмтэд тооны хувьд цөөн бус ч гаргаж буй бүтээлийн хувьд харьцангуй бага байдаг нь ажиглагдаж байна.

Бүртгэгдсэн бүтээлүүдийн зохиогчид болох судлаачдын тоонд анализ хийхэд дараах байдал ажиглагдлаа. Үүнд:

✓ Биологийн ухааны салбарын эрдэмтэн судлаачид 27, байгаль шинжлэл, газарзүйн салбарт 42, нийгэм, эдийн засгийн салбарт 42, түүх, соёл, угсаатны зүйн салбарын эрдэмтэд, судлаачид 32 байна.

Ийнхүү нийт 140 гаруй судлаачдын 600 гаруй бүтээлийг хамруулаад байна. Энэ баримт нь судалгааны бүтээлийн тоо нь судлаачдын олон цөөнөөс үл хамаарч байгааг илтгэж байна. Бүртгэгдсэн 600 гаруй бүтээлийн дотор гадаадын эрдэмтдийн болон манай эрдэмтдийн хамтарсан

хамтын бүтээл багагүй хувийг эзэлсэн болно.

Нийт бүтээлийн 6.5 хувь буюу 39 нь томоохон бүтээл хамрагдсан байна. Энэ бүтээлүүдийн бүтцэд ч дээр ангилсан үндсэн салбаруудын эзлэх хувь хэмжээ ойролцоо, гадаадын судлаач, эрдэмтэдтэй хамтрах үйл ажиллагаа нь ижил түвшинд байна.

Бидний үзэж байгаагаар социализмын тогтолцооноос өмнөх үе, социализмын төлөвлөгөөт эдийн засгийн үеийн болон зах зээлийн эдийн засгийн харилцаат нийгэмд шилжих үе гэсэн 3 ерөнхий хэсэгт хувааж үзэж болох байна. Нийгэм эдийн засгийн газарзүйн аливаа судалгаанд тухайн нийгмийн хууль, зүй тогтол шийдвэрлэх нөлөөтэй байдгийг харгалзан, бүсчилсэн хөгжлийн судалгаанд хандах хандлага, нийгмийн хөгжлийн хууль, улс орноо нутаг дэвсгэрээр нь хөгжүүлэх асуудал, түүнд гарсан хандлагын өөрчлөлттэй холбоотой ийнхүү ангилж байна.

Эхний хэсэг буюу социализмын тогтолцооноос өмнөх үед Монгол улсад бүсчлэн хөгжүүлэх үзэл санаа нь анхны төрт улс болох Хүннүгийн үеэс улс гүрнээ баруун, зүүн, төвийн хэсэгт хуваан, төр засгаа засаж байснаас эхлэлтэй ба энэ талаар түүхч Х.Нямбуу тэмдэглэн үлдээсэн байна. Энэ нь эрт цагаас эхлэн монголчууд бүсчилсэн хөгжлийн агуулгаар нутаг орноо хуваарилан тохинуулж байсныг гэрчилж байна. Түүнчлэн XIII-XIV зуунд Чингис хаан Монголын нэгдсэн гүрнийг байгуулаад төр улсаа 3 түмэнд хуваан, дотор нь аравт, зуут, мянгатаар хуваарилан удирдаж байсан хэмээн судлан бичжээ. [Монголын өрнөд нутгийн хүн амын аж төрөх ёсны хөгжил. (1989)] [4]

1691 онд Манж нар монголыг эзэлж улмаар халхчуудын хүчийг бутаргах зорилгоор 1725 онд Сайнноён хан аймгийг шинээр нэмж, Халх 3 аймгийг 4 аймаг болгожээ. 1733 онд Улиастайд халх 4 аймгийн чуулганы даргын газрыг байгуулж, тухайн үед байсан 34 хошууг 74 хошуу болгон жижиглэж, энэхүү өөрчлөлтөөр Түшээт хан аймгийг халхын хойт зам, Цэцэн хан аймгийг өмнөд зам, Сайнноён хан аймгийг дундад зам, Засагт хан аймгийг баруун зам хэмээн нэрлэх болжээ. Энэ нь засаг захиргааны хуваарийн төдийгүй бүсчлэлийн асуудал мөн адил хамт яригдаж байсныг илтгэнэ. [Монголын өрнөд нутгийн хүн амын аж төрөх ёсны хөгжил. (1989)] [4]

Хоёрдугаар хэсэг болох социализмын төлөвлөгөөт эдийн засгийн үед Монгол улсад бүсчлэн хөгжүүлэх үзэл санаа, судалгаа нь төр засгийн болон эрдэмтдийн анхааралд орж, тодорхой үзэл санаанууд боловсрогдон зарим нэгэн шийдвэрт хүрч эхэлсэн байна. 1921 онд монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл бүрэн ялж, феодалын ёсыг халж, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын тухайд Түшээт

хан аймаг 21, Сэцэн хан аймаг 25, 9 тамгатай шавь, Сайн ноён хан аймаг 25, тамгатай шавь 8-тай, Засагт хан аймаг 20, тамгатай шавь 3-тай, Их шавь 200 гаруй отог, багтай, Дөрвөдийн 2 аймаг 16 хошуутай байсан гэж ахмад түүхч Ц.Сономдагва бичсэн байна. [4]

БНМАУ-д 1961 онд Монгол, зөвлөлтийн хэсэг эрдэмтэд монголын нутаг дэвсгэр дээр Төв, Дорнод, Өрнөд гэсэн эдийн засгийн гурван бүс бүрдэх хандлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрсэн нь энэ талын судалгаа шинжилгээний ажлын анхны томоохон үр дүн байв [Алампиев.П.М, (1962)]. Тэрээр өрнөд бүсэд баруун зургаан аймгийг (Баянхонгорыг оруулан) хамруулсан бүсчлэлийн анхны схемийг боловсруулж байжээ. Энэхүү судалгааны багт монголоос Б.Гунгаадаш, Ч.Сэрээтэр, Ш.Бат-Очир, Д.Бадамжав, С.Жадамбаа, Ш.Цэгмид, Ц.Даваажамц, Г.Сандагжав, С.Ичинхорлоо, Т.Норжмаа, Ш.Цэвэг, Х.Дашдондов, Л.Гүржав, Т.Намжим, зөвлөлтийн талаас П.М.Алампиев, В.В.Кистанов, М.В.Мазанова, Д.А.Чумичев, А.А.Аврамова, Н.Т.Кузнецов, И.И.Горидько зэрэг эрдэмтэн судлаачид оролцож бүсчлэлийн суурь судалгааг хийсэн байна. Хожим судлаач Т.Энэбиш, Б.Лхагвадорж нар 1985 онд "БНМАУ-ын эдийн засгийн мужлалт" нэртэй өгүүлэл хэвлүүлсэн ба Төв бүсийг Хойд ба Говийн, Өрнөд бүсийг Завхан-Говь-Алтайн ба Ховд-Увсын гэсэн дэд мужид ангилах санал дэвшүүлжээ [Энэбиш.Т., Лхагвадорж.Б, (1985)]. [4]

1964 онд ХАА-н хөгжил байршлыг голлон анхаарч, эдийн засгийн 4 бүсийн хувилбарыг санал болгосон байна. Эрдэмтэн Б.Гунгаадаш Төв бүс (10 аймаг)-ийг дотор нь 4 дэд муж, Өрнөд бүс (баруун 5 аймаг)-ийг дотор нь 2 дэд муж болгох санал дэвшүүлж бүс, дэд мужуудын тодорхойлолтыг 1986 онд өгсөн байна [Гунгаадаш.Б., (1986)] [4]. Мөн 1980 онд Л. Цэдэндамба, О.Сүхбаатар, Ч.Дуламсүрэн нар хамтран эдийн засгийн Өрнөд, Дорнод, Төв бүсийн хүрээнд 7 дэд бүс илрүүлэх саналыг дэвшүүлсэн байна. [Цэдэндамба.Л. бусад., (1980)] [4]. Эдгээр судлаач эрдэмтдийн бүтээл, үзэл, санааны үр дүнд Монгол улсад бүсчилсэн хөгжлийн үзэл нэг мөр тогтворжсон байна.

Гуравдугаар хэсэг болох зах зээлийн эдийн засгийн харилцаат нийгмийн үед Монгол улсад бүсчлэн хөгжүүлэх үзэл санаа, судалгаа нь зах зээлийн тогтолцоот орнуудын нийтлэг жишигт нийцсэн, манай улсын хувьд шинэ гэж хэлж болох бүсчилсэн хөгжлийн бодлоготой болохын тулд юуны өмнө бүсчилсэн хөгжлийн талаар баримталж байсан онол, аргазүйн хандлагаа эрс шинэчилж эхэлсэн байна. Онолын энэхүү хандлагын үзэл санаа анх Монгол Улсын шинэ Үндсэн хууль (1992 оны)-д тусгалаа олсон юм [4].

Төр, засгийн шийдвэр гаргах хэмжээний субъектүүдээс гадна эрдэмтэн судлаачдын




бүтээлд [Л.Цэдэндамба, (1996); Н.Батцэрэг, Л.Цэдэндамба, (1998); Л.Цэдэндамба, А.Энх-Амгалан, (1999); Л.Цэдэндамба, Х.Маам, (1999); Х.Батцэнгэл, (1997); Д.Моёбуу, (1998); Л.Цэдэндамба, (1999) Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх асуудлыг онолын хувьд боловсруулж, үзэл бодлоо илэрхийлж байсан ажээ [4].

Энэ үед судлаачид маш сонирхолтой бодууштай судалгаа хийж, янз бүрийн шийдлийг боловсруулж байсан байна. Тухайлбал: З.Олонбаяр 1993 онд “Засгийн газрын мэдээ” сонинд “Таван төвтэй бүсийн тогтолцоонд шилжье” өгүүлэл, доктор Х.Дашдондов, судлаач З.Олонбаяр нарын хүмүүс 1999 онд “Монгол орныг бүсчлэн хөгжүүлэх асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, Н.Тогтох дээрх судлаачдын бүтээлд тулгуурлан мөн ийм агуулгатай өгүүллийг 1996 онд “Улаанбаатарын мэдээ” сонинд нийтлүүлж, доктор (PhD) Б.Батхишиг “Монгол орныг бүсчлэн хөгжүүлэх аргазүйн зарим асуудал” нэртэй өгүүлэлдээ дээрх судлаачдынхтай ерөнхийдөө ойролцоо боловч зарим шинэлэг хандлагыг агуулсан саналыг дэвшүүлсэн бол судлаач Г.Чулуун [Чулуун.Г, (1998)] “Орон нутгаас төв рүү чиглэсэн их нүүдлийг эхлүүлье” гэсэн өвөрмөц нийтлэл бичиж байсан байна. Мөн доктор Д.Базаргүр “Зохиомол хил бүхий олон бүс нутаг байж таарамгүй” [Базаргүр.Д. бусад., (1997)] нэртэй өгүүлэл бичиж, “Тэнхлэггүй бүс нутаг цогцолбороор хөгжиж чадахгүй» гэсэн нэртэй өөр нэгэн өгүүлэлдээ [Базаргүр.Д. бусад., (1998)] [4] эдийн засгийн бүсчлэлийг дахин үгүйсгээд, Монгол оронд зам харилцаа хөгжүүлэх газрын гадаргуугийн бартаажилт зэргээс үзэхэд одоогоор үүсэж байгаа хамгийн тохиромжтой гурван босоо тэнхлэг (Дорнод, Төв, Өрнөд)-ийн хувилбарыг дэвшүүлж байгаагаа илэрхийлж байжээ. Судлаач Г.Нямдаваа 2001 онд “Шинжлэх ухааны академи”-ийн “Газарзүйн хүрээлэн”-гийн эрдэм шинжилгээний бүтээлд “Ховд хотыг баруун бүсийн тулгуур төв болгох тухай асуудалд” сэдэвт өгүүлэл нийтлүүлж, Увс, Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан хурлуудад хэд хэдэн удаа илтгэл хэлэлцүүлж байсан нь баруун бүсийн бүсчлэл, түүний тулгуур хотыг сонгох сонголтод тодорхой үүргийг гүйцэтгэсэн байна. Эндээс үзэхэд монголын судлаач эрдэмтэд, зүгээр суулгүй, улс орны хөгжил, эдийн засгийн үзүүлэлтэд анхаарал хандуулж, янз бүрийн үзэл, санааг эрэлхийлж, түүнийгээ илэрхийлж байсан ба нэг цэг дээр хараахан төвлөрч байгаагүй нь цаг үе түүхийн хуудаснаа үлдсэн байна.


Харин өнөөдөр судлаачид, эрдэмтэд, төр засгийн шийдвэр гаргах эрх бүхий субъектүүд хамтран тодорхой шийдэлд хүрч, амжилттай ахин дэвшиж, улс орон нутаг дэвсгэрийн хөгжих үндэс, сууриа нэгэнтээ боловсруулж чадсан хэмээн хэлж болох байна.

Монгол орны бүсчлэлийн түүхэн шийдвэрүүдийн зураг. [4. х 28, 36, 40]


Хот байгуулалт болон ЗБ-ын 1997 оны бүсчлэл



Орос-Монгол хамтарсан 1961 оны бүсчлэл



МУ-ын эдийн засгийн 1997 оны бүсчлэл



ДҮГНЭЛТ, САНАЛ

Бүсчлэлийн асуудал нь судалгааны суурь, үндэслэлтэйгээр бий болж, шийдвэрлэгдэх зүйл бөгөөд цаашид улам боловсронгуй болон хөгжиж, үр дүн, цар хүрээ нь нэмэгдэхэд үе үеийн судлаачдын бүтээл тулгуур үндэслэл болох юм.

Баруун бүс нутагт харьяалагдаж буй сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, хувь судлаачид өөрсдийн бүтээл, судалгаа, үзэл, санаагаа цаг үргэлж илэрхийлсээр байгаа нь харагдсан ба эдгээрт үнэлэмж өгч, үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх буюу инновацийг хөгжүүлэх алхмыг хийх шаардлагатай байна.

Судлаачдын анхаарлыг бүс нутгийн хэтийн хөгжлийн болон тулгамдсан асуудлыг

шийдвэрлэх чиглэлүүдэд хандуулж, шинжлэх ухаан, нийгмийн хөгжил хоёрыг уялдуулах шаардлагатай юм.

Энэхүү өгүүлэлд судалгааны бүртгэгдсэн материалуудад ерөнхий анализ хийсэн бөгөөд цаашид улам баяжуулж, судалгааны чиглэлийг илүү нарийвчилж, шийдлийг эрэлхийлэх болно.

Ийнхүү олон арван судлаачийн анхаарлыг нэгэн чиглэлд төвлөрүүлэх, хамтран ажиллах боломж олгоход төр захиргааны байгууллагын дэмжлэгтэй арга хэмжээг зохион байгуулах нь судлаачдын ажлын үр дүн, санал зөвлөмжийг практикт хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Шинжлэх Ухааны Академи. Баруун бүсийн зөвлөл. (2010). Баруун бүсийн хөгжил, шинжлэх ухаан, технологи, ЭШ-ний бага хурлын илтгэлийн эмхэтгэл
- Монгол Улсын Их Сургууль, Завхан салбар сургууль .(2009). *Эрдэм Шинжилгээний бичиг, 4*
- Нямдаваа, Г. (2004) . Ховд аймгийн байгаль нийгэм эдийн засаг
- Хүмүүнлэгийн Их Сургууль. БШТС-ийн. (2010). Биологийн тэнхимийн тайлан. Ховд
- Хүмүүнлэгийн Их Сургууль. Номын сангийн каталоги, электрон каталоги
- Хүмүүнлэгийн Их Сургууль. НХУС-ийн. (2010). *Эрдэм Шинжилгээний бичиг, 3 /15*
- Хүмүүнлэгийн Их Сургууль. БУФ-ийн. (2010). *Эрдэм Шинжилгээний бичиг 3 /15*
- Хүмүүнлэгийн Их Сургууль. БШТС-ийн. (2010). Газарзүйн тэнхимийн тайлан, Ховд
- Хүмүүнлэгийн Их Сургууль. Судалгаанд бүртгэгдсэн материалуудын жагсаалт гаргахад ашигласан бүтээлүүд
- Цэдэндамба, Л., Маам, Х., Батхишиг, О. (1999). *Монгол Улсын Өрнөд бүс. Улаанбаатар*